



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 23710014 тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР